

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код: 65.020.40

Мод, сөөгний үрийг тарихад бэлтгэх. Ерөнхий шаардлага	MNS 6253-1 : 2011
Preparing seeds of trees and shrubs for planting. General requirement	

Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн 2011 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 25 дугаар тогтоолоор батлав.

Энэ стандартыг улсын бүртгэлд бүртгэсэн өдрөөс эхлэн мөрдөнө.

1 Хамрах хүрээ

Энэ стандарт нь мод үржүүлгийн газар буюу ойжуулах талбайд тарих төрөл бүрийн мод, сөөгний үрийг тарихад бэлтгэхэд хамаарна.

2 Норматив ишлэл

Энэхүү стандартад дараах баримт бичгийг иш татсан бөгөөд эдгээр стандартад өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн албан ёсны материалаас иш татаж хэрэглэнэ.

- MNS 5994:2009, Мод, сөөгний үр. Тариалалтын чанар. Техникийн шаардлага,
- ГОСТ 13204:91, Яст болон үрт жимст модны үр. Тариалалтын чанар. Техникийн шаардлага,
- ГОСТ 13857:95, Мод, сөөгний үр. Тариалалтын чанар. Техникийн шаардлага,
- ГОСТ 14161:86, Шилмүүст модны үр. Тариалалтын чанар. Техникийн шаардлага.

3 Нэр, томъёо ба тодорхойлолт

3.1

Үрийн тайван байдал

Үр боловсорсоны дараа тодорхой хугацаанд тайван байдалд орох,

3.2

Үр ариутгах

Химийн төрөл бүрийн хордуулагч бодис ашиглан үрээ ариутгах явц,

3.3

Үр эртжүүлэх /стратификаци/

Үрийг тайван байдлаас нь гаргахын тулд зориудаар тарилтанд бэлтгэх арга,

3.4

Үр чийглэх

Үрийг хөөтөл нь чийглэх,

3.5

Үр цаслах

Савласан үрээ уутанд жигд тараан цасан дор хийх,

3.6

Үр элслэх

Мод, сөөгний үрийг элстэй үелүүлэн хийж, температурын тодорхой нөхцөлд тогтоосон хугацаанд байлгахыг хэлнэ.

4 Техникийн шаардлага

4.1 Мод, сөөгний үрийг тарихад бэлтгэхэд MNS 5994:2009 стандартын шаардлагыг хангасан байна.

4.2 Тарилтанд бэлтгэж байгаа мод, сөөгний үрийн цэвэршилтийг MNS 2433:2009, амьдрах чадварыг MNS 2432:2009, чийгийг MNS 2431:2009, соёлолтыг MNS 2887:2009, 1000 үрийн жинг MNS 2430:2009 стандартуудыг баримтлан лабораториор шинжлүүлсэн байна.

4.3 Мод, сөөгний үрийг элстэй хольж бэлтгэхийн өмнө элсийг угааж цэвэрлэн, сайн улайсгаж ариутгасан байвал зохино.

4.4 Мод, сөөгний үрийг тарилтанд бэлтгэх хугацаа 1-р хүснэгтэд заасан хэмжээнд байна.


Мод, сөөгний үрийг тарилтад бэлтгэх хугацаа

1-р хүснэгт

№	Ургамлын нэр	Усанд дэвтээх хугацаа	Цаслах, элслэх хугацаа /хоног/	Үрийг тарилтанд бэлтгэх арга
1	Гацуур	-	30-40	цаслах
2	Хуш	3 хоног	90	цаслах
3	Шинэс	2 хоног	30	цаслах
4	Нарс	2 хоног	30	цаслах
5	Жодоо	-	60-90	цаслах
6	Майлаас	2 хоног	30-40	Цаслах, элслэх
7	Арц	2 хоног	30-40	Цаслах, элслэх
8	Хайлаас	-	түүгээд шууд тарина	-
9	Хус	-	180-200	цаслах
10	Тэс	-	130-200	цаслах
11	Долоогоно	60% чийгтэй болтол дэвтээнэ	240	Цаслах, элслэх
12	Чацаргана	1 хоног	30	Цаслах, элслэх
13	Монос	2-3 хоног	60-90	Цаслах, элслэх
14	Гүйлс	2 хоног	45	Цаслах, элслэх
15	Бүйлс	2 хоног	45	Цаслах, элслэх
16	Өрөл	2 хоног	40	Цаслах, элслэх
17	Шар хуайс	1 хоног	30	Цаслах, элслэх
18	Нохойн хошуу	60% чийгтэй болтол дэвтээнэ	210	Цаслах, элслэх
19	Жигд	2 хоног	30	элслэх
20	Далан хальс	2 хоног	150-180	Цаслах, элслэх
21	Бургас	-	Түүгээд шууд тарина	-
22	Чаргай	2 хоног	180-200	Цаслах, элслэх
23	Улаагана	-	80-90	Цаслах, элслэх
24	Тошлой	-	45-60	Цаслах, элслэх
25	Голтбор	1 хоног	30	Цаслах, элслэх
26	Тавилгана	-	150-180	цаслах
27	Гандигар	1 хоног	45-60	Цаслах, элслэх

28	Агч	2 хоног	30	Цаслах, элслэх
29	Харгана	1 хоног	45-60	Цаслах, элслэх
30	Яргай	2 хоног	150-180	Цаслах, элслэх
31	Яшил	2 хоног	150-180	Цаслах, элслэх
32	Тэхийн шээг	1 хоног	45-60	Цаслах, элслэх
33	Мөнгөлөг жигд	1 хоног	45-60	Цаслах, элслэх
34	Шар мод	1 хоног	45-60	Цаслах, элслэх
35	Тэрэлж	2 хоног	45-60	Цаслах, элслэх
36	Тэсмэг	-	45-60	цаслах

4.5 Элслэх хайрцаг нь 25-аас 30 см өндөр, 30-аас 35 см өргөн, 50 см урт хэмжээтэй, 2 талдаа барих бариултай, тагтай байна /1-р зураг/.



1-р зураг. Үр элсэлсэн байдал

Элстэй үрийг 16-аас 20 см өндөр дэр модон дээр шатарчлан хурааж, 14-өөс 15 хоног тутам үрийг чийглэнэ.

4.6 Цасалсан үрийг цас хайлахгүй газар тавьж 1,5 м зузаан цасаар дарж, дээрээс нь сүрэл, үртсээр 50 см зузаан хучина.

ТӨГСӨВ.